

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН
ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
ЖАНЦАНДОРЖИЙН АЗЖАРГАЛЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | | |
|--|-------------------------------------|---------------------|---------------------|-----------------|-------------------------|--------------------------------|--------------------|--|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь | |
| | | | 1 | 2 | | | 7 | |
| НЭГ.ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | | |

2.2.МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖИЛ ОРОЛЦОOG ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, НИЙГМИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САЛБАР ДУНДЫН ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ЦОГЦ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ГЭР БҮЛ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

2.4.3-ЫН ХҮРЭЭНД:

Зорилт 1: Хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, оролцоог хангах

| | | | | | | | |
|----|---|---|----|---|--|------------------------------|------------------|
| 1. | Арга хэмжээ 1.1. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын МҮЗГ-ын 6,7 дугаар тайланг боловсруулж, НҮБ-ын хүүхдийн эрхийн хороонд хүргүүлнэ. /Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 5 дугаар зөвлөмжийн 49 дүгээр зүйл/ | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 0% | - | Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 03/771 дугаар албан бичгээр "Хүүхдийн эрхийн тухай конвенцын Хорооны Нарийн бичгийн дарга нарын газраас 2027 оныг хүртэл Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх ээлжит 6, 7 дугаар хамтатгасан илтгэлийг хялбаршуулсан журмаар бэлтгэж хүргүүлэх хуваарь хойшилсон"-ыг уламжилсан. | Тайлангийн хугацаа хойшилсон | Үнэлэх боломжгүй |
|----|---|---|----|---|--|------------------------------|------------------|

| | | | | | | | |
|----|---|---|----|-----|---|------------------|------|
| | Арга хэмжээ 1.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллыг сайжруулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн эзлэх хувь | 0% | 50% | <p>1/ Аймаг, дүүрэг, сум дундын шүүхтэй суманд 38 Хүүхдийн эрхийн хууль шинэчлэгдэн байгуулагдаж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40-43 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2/ Архангай, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Орхон, Говьсүмбэр аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулагдаж, 110 гишүүн, хорооны ажлын алба хамрагдаж, чадавхжсан.</p> <p>3/ ТНБД-ын 2025 оны "Журам боловсруулж, батлуулах тухай" А/85 дугаар тушаал батлуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.6-д заасан "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам"-ын төслийг боловсруулах ажлыг эхлүүлж, баримт бичгийн шинжилгээ хийгдэж байна.</p> | 2025.01-09-06.05 | 90% |
| 2. | Дэд арга хэмжээ 1.2.1. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн шинэчлэх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэл хүргүүлж, хяналт тавина. | Гүйцэтгэлийн хувь | 0% | 50% | <p>Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний 03/64 дугаар албан бичгээр Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40.1-40.6-д заасны дагуу шинэчлэн байгуулах, чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, үйлчилгээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай чиглэл хүргэсэн. Үүний үр дүнд 38 хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, Архангай, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Орхон, Говьсүмбэр аймаг, нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн Хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулагдаж, 110 албан хаагч, хууль зүйн хорооны ажлын албаны гишүүд сургалтад хамрагдан чадавхжсан байна.</p> | 2025.01.09 | 100% |
| 3. | | | | | | | |

| | | | | | | | |
|----|---|-------------------------|----|-----|--|------------------|-----|
| 4. | Дэд арга хэмжээ 1.2.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам боловсруулж, батлуулах тухай ТНБД-ын тушаал батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана. | Гүйцэтгэлийн эзлэх хувь | 0% | 40% | ТНБД-ын 2025 оны "Журам боловсруулж, батлуулах тухай" А/85 дугаар тушаал батлуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.6-д заасан "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам"-ын төслийг боловсруулах ажлыг эхлүүлсэн. Тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд ажлын хэсгийн хурлыг 1 удаа зохион байгуулж, журам боловсруулах төлөвлөгөөг шинэчилж, Хүүхдэд эзлтэй өрөөгөөр үйлчлүүлж байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч 7-оос дээш насны хүүхэд, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс авах сэтгэл ханамжийн судалгааны асуумж боловсруулж байна. Мөн журам боловсруулахад шаардагдах баримт бичгийн шинжилгээ хийгдэж байна. Баримт бичгийн шинжилгээг ажлын хэсгээр дүгнэн хэлэлцэж, журмын хүрээг тогтоож боловсруулах ажлыг хийнэ. | 2025.03.26-06.05 | 70% |
|----|---|-------------------------|----|-----|--|------------------|-----|

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 2: Хүүхдийн хөгжил, хамгаалал, хүн амын бүлгүүдийн цогц хөгжил, оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах

| | | | | | | | |
|----|---|---|----|-----|---|------------------|-----|
| 5. | Арга хэмжээ 2.1. Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг сурталчлан таниулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 0% | 50% | Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг сурталчлан таниулна ажлыг зохион байгуулж, 15 зурагт постор, 6 видео боловсруулж, олон нийтэд түгээсэн. Мөн эхний хагас жилийн байдлаар батлагдсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлж мөрдөх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын албан хаагч 243 хүн, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 30 сурагчид сургалт зохион байгуулсан. Хэвлэл мэдээллийн ярилцлага 8, подкаст-1 тус тус өгсөн байна. | 2025.01.06-06.05 | 90% |
| 6. | Дэд арга хэмжээ 2.1.1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн онцлог | Гүйцэтгэлийн эзлэх хувь | 0% | 40% | Хүүхэд хамгааллын тухай хуулийн онцлог зүйл заалтыг олон нийтэд сурталчлан таниулна зорилгоор 15 зурагт хуудас, 6 видеог Олон | 2025.01-04.30 | 90% |

| | | | | | | | |
|----|---|---|-----|-----|---|------------------|------|
| | зүйл заалтыг таниулсан 11 постор, 6 видео контент хийнэ. | | | | нийттэй харилцах ахлах мэргэжилтэн, яамны хэвлэл мэдээллийн багтай хамтран боловсруулав. | | |
| 7. | Арга хэмжээ 2.2. Хүүхэд хамгааллын тухай хуулийг /шинэчилсэн найруулга/ даган гарах журам, стандартыг боловсруулна. (МУХТЖҮЧ-ийн 2.3.1, 2.3.3, 2.3.5) | Журам, стандартын төсөл боловсруулал -тын гүйцэтгэлийн хувь | 30% | 50% | <p>Хүүхэд хамгааллын тухай хуулийг даган гарах 2 журам, 3 стандартыг батлуулж, мөрдөн ажиллаж байна.</p> <p>-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн A/11 дүгээр тушаалаар “Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”;</p> <p>-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Журам батлах тухай” А/53, А/95, А/76 дугаар тушаалаар “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”;</p> <p>-MNS 7065:2025, Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага</p> <p>-MNS 7066:2025, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага</p> <p>-MNS 5852:2025, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага тус тус батлагдаж, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.</p> <p>-2025 оны 1,2 дугаар улиралд аймаг, нийслэл, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар/хэлтсийн 120 албан хаагч, сум, хорооны 623 нийгмийн ажилтан, хамтарсан багийн 2100 гишүүдэд журам, стандартууд болон Засгийн газрын 2024 оны 236 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг</p> | 2025.01.06-06.05 | 100% |

| | | | | | | | |
|-----|--|---|-----|------|--|------------------|------|
| | | | | | санхүүжүүлэх аргачлал, хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив"-ыг хэрэгжүүлж, мөрдөх арга зүйн чадавхжуулах сургалт зохион байгуулсан. | | |
| 8. | Дэд арга хэмжээ 2.2.1. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг батлуулах | Журмын төсөл боловсруулал -тын гүйцэтгэлийн хувь | 50% | 100% | <p>ГБХНХ-ын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг батлуулсан. Батлагдсан журмыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн. https://legalinfo.mn/mn/detail?lawId=173558486015 91</p> <p>Журмын танилцуулах сургалтыг 2025 оны 2 дугаар сард зохион байгуулагдан Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг мэргэшүүлэх сургалтын оролцогч 623 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд танилцуулсан.</p> | 2025.01.17-02.15 | 100% |
| 9. | Дэд арга хэмжээ 2.2.2. Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам батлуулах | Журмын төсөл боловсруулал -тын гүйцэтгэлийн хувь | 50% | 100% | <p>ЦХИХХ-ны сайд, ХЗДХ-ийн сайд, ГБХНХ-ын сайд нарын хамтарсан 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн "Журам батлах тухай" А/53, А/95, А/76 дугаар тушаалаар баталсан. Журмыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн. Журмын танилцуулах сургалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар/хэлтсийн дарга, хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн 120 хүнд зохион байгуулсан.</p> | 2025.01.06-06.05 | 100% |
| 10. | Дэд арга хэмжээ 2.2.3. Хүүхдэд сэтгэл зүйн тусlamж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлагыг батлуулах | Стандартын төслийн боловсруулал тын гүйцэтгэлийн хувь | 70% | 100% | <p>Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8.6-д заасан Хүүхдэд сэтгэл зүйн тусlamж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлагын төслийг 2024 оны 6 сараас боловсруулж, 2024 оны 12 сарын 26-ны өдрийн Стандартчилал, хэмжил зүйн газрын ТХ-46 хороогоор хэлэлцүүлж, хорооны гишүүдийн саналыг тусган сайжруулж, 2025 оны 1 дүгээр сард баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд MNS 7065:2025, Хүүхдэд сэтгэл</p> | 2025.01.06-03.30 | 100% |

| | | | | | | | | |
|-----|---|--|-----|------|--|--|------|--|
| | | | | | | зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага батлагдаж, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Уг стандартыг танилцуулах сургалтыг Хүүхэд хамгааллын зардлын аргачлал, нормативыг мөрдөх арга зүйн сургалтын оролцогч бөгөөд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар/хэлтсийн дарга, хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн 120 хүнд зохион байгуулсан. | | |
| 11. | Дэд арга хэмжээ 2.2.4. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг батлуулах | Стандартын төслийн боловсруулалтын гүйцэтгэлийн хувь | 70% | 100% | Xүүхэд хамгааллын тухай хуулийн 8.6-д заасан "Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага"-ын төслийг 2024 оны 6 сараас боловсруулж, 2024 оны 12 сарын 26-ны өдрийн Стандартчилал, хэмжил зүйн газрын TX-46 хороогоор хэлэлцүүлж, хорооны гишүүдийн саналыг тусган сайжруулж, 2025 оны 1 дүгээр сард баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд MNS 7066:2025, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага батлагдаж, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Уг стандартыг танилцуулах сургалтыг Хүүхэд хамгааллын зардлын аргачлал, нормативыг мөрдөх арга зүйн сургалтын оролцогч бөгөөд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар/хэлтсийн дарга, хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн 120 хүнд зохион байгуулсан. | 2025.01.06-03.30 | 100% | |
| 12. | Дэд арга хэмжээ 2.2.5. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг батлуулах | Стандартын төслийн боловсруулалтын гүйцэтгэлийн хувь | 70% | 100% | Xүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг шинэчлэн боловсруулж, 2024 оны 12 сарын 26-ны өдрийн Стандартчилал, хэмжил зүйн газрын TX-46 хороогоор хэлэлцүүлж, хорооны гишүүдийн саналыг тусган сайжруулж, 2025 оны 1 дүгээр сард баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд MNS 5852:2025, | 2025.01.06-04.20 | 100% | |

| | | | | | | | | |
|-----|--|---|-----|-----|---|---|-----|--|
| | | | | | | Xүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага батлагдан, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус стандартыг Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад мөрдүүлэх арга зүйн сургалтыг Хүүхэд, гэр булийн хөгжил, хамгааллын ерөнхий газар/хэлтсийн 32 албан хаагчид зохион байгуулсан. | | |
| 13. | Дэд арга хэмжээ 2.2.6. Жагсаал, цуглааны үеийн хүүхэд хамгааллын нийтлэг шаардлагын төслийг боловсруулж, батлуулах | Стандартын төслийн боловсруулалтын гүйцэтгэлийн хувь | 40% | 30% | Жагсаал цуглааны үеийн хүүхэд хамгааллын стандартын төсөлд санал авах хэлэлцүүлгийг хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн албан хаагчдын дунд зохион байгуулж, оролцогчдоос өгсөн саналыг нэгтгэн төсөлд тусгасан. Стандартын төслийг Стандартчилал, хэмжил зүйн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын техникийн хорооны (TX-46) гишүүдээс санал авахаар хүргүүлсэн. Хүүхдийн хөгжил, хамгааллын техникийн хорооны (TX-46) хурлыг 2025 оны 6 сарын 18-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна. | 2025.01.06-2025.06-05 | 90% | |
| 14. | Дэд арга хэмжээ 2.2.7. Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Нярай хүүхэд, хөхүүл ээжид зориулсан өрөө. Ерөнхий шаардлага стандарт"-ын төслийг сайжруулж, бурдүүлбэрийг бэлтгэж байна. Стандартын төслийг Стандартчилал, хэмжил зүйн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын техникийн хорооны (TX-46) гишүүдээс санал авахаар хүргүүлсэн. Хүүхдийн хөгжил, хамгааллын техникийн хорооны (TX-46) хурлыг 2025 оны 6 сарын 18-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна. | Стандартын төслийн боловсруулалттын гүйцэтгэлийн хувь | 40% | 30% | Боловсруулагч нартай хамтран ажиллаж, "Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Нярай хүүхэд, хөхүүл ээжид зориулсан өрөө. Ерөнхий шаардлага стандарт"-ын төслийг сайжруулж, бурдүүлбэрийг бэлтгэж байна. Стандартын төслийг Стандартчилал, хэмжил зүйн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын техникийн хорооны (TX-46) гишүүдээс санал авахаар хүргүүлсэн. Хүүхдийн хөгжил, хамгааллын техникийн хорооны (TX-46) хурлыг 2025 оны 6 сарын 18-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна. | 2025.01.06-2025.06-05 | 90% | |
| 15. | Арга хэмжээ 2.2.8. Хүн худалдаалах гэмт | Журмын төсөл | 0% | 30% | Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын төслийг | 2025.01.06-06.05 | 70% | |

| | | | | | | | |
|-----|---|---|-----|-----|--|------------------|------|
| | хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран боловсруулна. (ХХ-ын тухай хууль, ХХТ тухай хууль) | боловсруулалттын гүйцэтгэлийн хувь | | | боловсруулж, Салбар дундын хамтарсан багийн гишүүдээс санал авах ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран 2025 оны 06 сарын 05, 06-нд зохион байгуулж байна. Журмын төслийг сайжруулж, олон нийтээс санал авах, батлуулах ажлыг 2025 оны 3 дугаар улиралд гүйцэтгэнэ. | | |
| 16. | Арга хэмжээ 2.3.Төрийн байгууллага, аж ахуйн нэгжид “Хүүхэд хамгааллын бодлого” мөрдүүлнэ. /ЗГУАХ 2024-2028 - 2.1.1.5/ | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 10% | 30% | Улсын хэмжээнд 4579 байгууллага, аж ахуй нэгж Хүүхэд хамгааллын бодлого баталж, 10053 байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулагдаж, 1014 байгууллага хүүхдийн өрөө тохижуулж, 103 байгууллага дэргэдээ хүүхдийн цэцэрлэг байгуулан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн. Хүүхэд хамгааллын тухай хуультай /Шинэчилсэн найруулга/ нийцүүлэн “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг шинэчлэн боловсруулж байна. | 2025.01.06-06.05 | 100% |
| 17. | Дэд арга хэмжээ 2.3.1. Хүүхэд хамгааллын бодлогыг шинэчлэн боловсруулах | Гүйцэтгэлийн хувь | 0% | 30% | Хүүхэд хамгааллын тухай хуультай /Шинэчилсэн найруулга/ нийцүүлэн “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлсэн. Төсөлд санал авах хэлэлцүүлгийг 2025 оны 7 дугаар сард, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүдээс санал авах ажлыг 8 сард, төслийг батлуулах ажлыг 9 дүгээр сард зохион байгуулна. Мөн энэ хүрээнд Австрали улсын Хүүхэд хамгааллын бодлогыг уншиж судалсан. | 2025.01.06-06.05 | 100% |
| 18. | Арга хэмжээ 2.4. Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөр батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 0% | 60% | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/121 тушаалын хавсралтаар “Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөр”-ийг батлуулсан. | 2025.01.09-05.30 | 100% |

| | | | | | | | |
|-----|--|---|----|------|--|------------------|------|
| 19. | Дэд арга хэмжээ 2.4.1. Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулж, санал авах, батлуулах | Гүйцэтгэлийн эзлэх хувь | 0% | 100% | Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулж, санал авах уулзалтыг Хүүхэд, гэр, бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, хүүхдийн эрхийн улсын байцаагчдын дунд цахим болон танхимиын хэлбэрээр зохион байгуулсан. Мөн хөтөлбөрт ХЗДХЯ, ЦХИХХЯ, БЯ зэрэг байгууллагын саналыг авч тусган боловсруулж, батлуусан. | 2025.01.09-05.30 | 100% |
| 20. | Дэд арга хэмжээ 2.4.2. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийн хэрэгжилтэд хяналт тавина. | Гүйцэтгэлийн эзлэх хувь | 0% | 50% | Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийн хэрэгжилтийг хангуулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөөг хүүхдийн эрхийн улсын байцаагч наарт өгч хамтран ажиллаж байна. Мөн ХЭҮБ-ын 2025 онд хийх урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. | 2025.01.09-05.30 | 100% |
| 21. | Арга хэмжээ 2.5. Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны хүрээнд зөвлөгөөн зохион байгуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 0% | 60% | Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан “Ахиц гарсан ч ахиад урагшлахад хүчээ нэмье!” уриан дор “Хүүхдийн хөдөлмөрт хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь” зөвлөлдөх уулзалтыг яам, агентлаг, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хүүхдийн төлөөлөл нийт 80 хүн оролцуулан зохион байгуулж байна. | 2025.05.26-06.05 | 80% |
| 22. | Дэд арга хэмжээ 2.5.1. Зөвлөгөөн зохион байгуулах тушаал, удирдамж батлуулна. | Гүйцэтгэлийн эзлэх хувь | 0% | 40% | <p>“Ахиц гарсан ч ахиад урагшлахад хүчээ нэмье!” уриан дор “Хүүхдийн хөдөлмөрт хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь” зөвлөлдөх уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн зэн Монгол ОУБ-тай уулзалт хийж, зөвлөгөөний үйл ажиллагааны санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. - Зөвлөгөөний хөтөлбөрт санал авах, бэлтгэл ажлыг хангах уулзалтыг 2 удаа зохион байгуулсан. | 2025.05.26-06.05 | 100% |

| | | | | | | | |
|-----|---|---|------|-----|---|------------------|------|
| | | | | | <ul style="list-style-type: none"> - Холбогдох яам, агентлагаудад албан бичгээр хөтөлбөрийг илгээж, оролцогчдын нэр авч байна. | | |
| 23. | Арга хэмжээ 2.6. АНУ-ын Засгийн газар болон МҮ-ын Засгийн газар хоорондын “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хэрэгжилтийг хангах, салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүрээнд Салбар дундын ажлын хэсгийн хурал 2 удаа, төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Дэлхийн зэн Монгол ОУБ-тай 4 удаагийн уулзалт зохион байгуулсан. Үүний үр дүнд : | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 100% | 50% | <ul style="list-style-type: none"> - Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын харьяа бэлгийн хүчирхийлэл, мөлжлэгийн хохирогч хүүхдийг нөхөн сэргээх “Гэрэлт нар өргөө” төвөөр үйлчлүүлж буй хохирогч хүүхдийн эргэн нийгэмших үйлчилгээнд дэмжлэг авч 2025 оны 1-2-р сард нийт 8 хүүхдийг гоо сайханч, үсчин, маникур зэрэг мэргэжлийн сургалтад хамруулсан. - Хүүхдийн эрхийн улсын байцаагчдыг АНУ-ын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сайн туршлагатай танилцах уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. - Мөн хүн худалдаалах гэмт хэрэг, ялангуяа бэлгийн мөлжлэгээс урьдчилан сэргийлэх агуулгын хүрээнд “Мөрөөдлийнхөө зүг” аяны 2 дахь шат буюу хөдөлмөрийн мөлжлэгээс урьдчилан сэргийлэх агуулгын хүрээнд 2025 оны 9-10-р сард зохион байгуулахаар төлөвлөлт хийгдэж байна. <p>Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад тус төслийн талаарх мэдээлэл, үр дүн,</p> | 2025.01.06-06.05 | 100% |

| | | | | | | | |
|-----|--|-------------------|---|-----|---|------------------|------|
| | | | | | цаашид хэрэгжүүлэх ажлын санал зэрэг мэдээллийг 2 удаа боловсруулж өгсөн. | | |
| 24. | Дэд арга хэмжээ 2.6.1. Нийслэлийн Чингэлтэй, Баянзүрх дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дэргэдэх түр хамгаалах байр, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байруудад “Хүүхдэд ээлтэй өрөө” байгуулна. | Гүйцэтгэлийн хувь | 0 | 30% | АНУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Хүүхэд хамгааллын туншлэлийн компакт гэрээ”-г хэрэгжүүлэгч Дэлхийн зөн Монгол ОУБ-тай уулзалт хийж, хүүхдэд ээлтэй өрөөг тохижуулахад техникийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах санал тавьж шийдвэрлүүлсэн. Уг ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх Хүүхдэд ээлтэй өрөө болон үйл ажиллагатай танилцаж, аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд, шүүгч, мөрдөгч нартай уулзалт хийсэн. Мөн сонгосон З газарт “Хүүхдэд ээлтэй өрөө” байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох уулзалтууд хийгдэж дууссан. Хүүхдэд ээлтэй өрөө тохижуулах ажлыг 2025 оны 3 дугаар улиралд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. | 2025.01.06-06.05 | 100% |

ГУРАВ. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

5.1.”ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх”

| | | | | | | | |
|----|---|---|------|-----|--|-------------------|------|
| 1. | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 100% | 50% | -Холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн тогтоол шийдвэрийн биелэлтийн тайлан мэдээг тухай бүр боловсруулж тайлагнасан. - Иргэд, олон нийтээс ирсэн өргөдөл, гомдлын хариуг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж ажилласан. | 2025.01.01-06 сар | 100% |
|----|---|---|------|-----|--|-------------------|------|

5.2. Архив, албан хэрэг хөтөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг

зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.

| | | | | | | | |
|----|---|---|------|-----|---|-------------------|------|
| 1. | Авилгын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 100% | 50% | 2025 оны ХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлж, баталгааны хуудсыг холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. | 2025.01.15-12 сар | 100% |
|----|---|---|------|-----|---|-------------------|------|

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|-----|--|------------------|---------------------|--------------|-------------------------|--------------------------|-----------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | |
| 1. | Арга хэмжээ 1.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн мэргшүүлэх сургалтад хамрагдсан байна. | Суралцсан цаг | 0 | 24 цаг | Хугацаа болоогүй. | - | - |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хүүхдийн эрхийн хууль тогтоомж,
бодлого, төлөвлөлт хариуцсан
шинжээч
(Албан тушаал)

Ж.Азжаргал/

(Нэр, гарын үсэг)

(Огноо)